

## Хавдрын эмчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн шалгалтын жишиг сорил

1. Нэг сонголттой тест ( Зөвхөн 1 хариулт зөв байх ) Энэ хэлбэрийн сорил нь А, В, С, D, E гэсэн дугаартай бөгөөд Зөвхөн 1 зөв хариуг сонгоно.
2. Олон сонголттой тест ( Хэдэн ч хариулт зөв байж болох )
  - 1, 2, 3 дугаар хариултууд зөв бол (А.)
  - 1, 2, 3, 4 дугаар хариултууд зөв бол (В.)
  - 2 ба 4 дугаар хариултууд зөв бол (С.)
  - Зөвхөн 4-р хариулт зөв бол (D.)
  - Бүх хариулт зөв бол (Е.)
3. Шалтгаан хамаарлын тест (Заагдсан тестүүдийн үнэн зөв хийгээд тэдгээрийн шалтгаан хамаарлыг тодорхойлно.)
  - Зөв, Зөв, Зөв (А.)
  - Зөв, Зөв, Буруу (В.)
  - Зөв, Буруу, Буруу (С.)
  - Буруу, Зөв, Буруу (D.)
  - Буруу, Буруу, Буруу (Е.)

### Сонгогдсон сорил

- /1./ Уушигны хорт хавдрын өндөр эрсдэлтэй бүлэгт аль нь багтах бэ?
  - А. Удаан хугацаанд тамхи татсан
  - В. Архаг бронхиттэй хүмүүс
  - С. Асбест, хром, никель гэх мэт химийн бодистой ажилладаг хүмүүс
  - Д. Дээрх бүгд зөв
  - Е. Зөвхөн А баВ зөв
- /2./ Нойр булчирхайн хорт хавдрын шарлалтын үед өтгөний өнгө ямар байх бэ?
  - А. Ердийн өнгөтэй
  - В. Хар-хүрэн
  - С. Давирхай шиг өнгөтэй
  - Д. Өнгөгүй
  - Е. Ямар нэг зүйтогтол байхгүй
- /3./ Ходоодны хавдрын үед ямар эс оношлогдохгүй вэ?
  - А. Аденокарцинома
  - В. Перстновид карцинома
  - С. Хавтгай хучуур эс
  - Д. Ялгаралгүй аденокарцинома
  - Е. Аль нь ч биш
- /4./ Ямар хавдар нь тавилан сайтай вэ?
  - А. Педжетийн хавдар
  - В. Зангилаат хөхний хавдар
  - С. Нэвчдэст хөхний хавдар
  - Д. Нэвчдэст хавантай хөхний хөвдөр
  - Е. Рожа төст хавдар
- /5./ Орчин үед хавдрыг юу гэж тайлбарлаж байгаа вэ?
  - А. Генетикийн өвчин
  - В. Халдварт өвчин
  - С. Үрэвсэлт өвчин
  - Д. Нийгмийн өвчин

Е. Харшлын өвчин

/6./ Хорт хавдрын эмгэгийн үед зайлшгүй ямар шинжилгээ хийх вэ?

- A. Цээжний хөндийн рентгенографи
- B. Хэвлийн хөндийн эхо
- C. Ясны радиоизотопийн шинжилгээ
- D. Морфологи бүтцийн шинжилгээ
- E. Бөөрний изотопын шинжилгээ

/7./ 23 настай эмэгтэйн эсийн шинжилгээнд тодорхой хэв шинжгүй хучуур эдийн гэмтэц илэрсэн (ASCUS) байна. Таны тактик?

- A. Эсийн шинжилгээг 4 сарын дараа давтах
- B. Кольпоскопи хийх
- C. Аль нь ч биш
- D. HPV –DNA тест
- E. Дээрх бүгд зөв.

/8./ Хөхний хавдрын аль хэлбэр нь тавилан сайтай вэ?

- A. Педжетийн хавдар
- B. Зангилаат хөхний хавдар
- C. Нэвчдэст хөхний хавдар
- D. Нэвчдэст хавантай хөхний хавдар
- E. Ёлом төст хавдар

/9./ Доор дурдсан хүчин зүйлсийн аль нь нойр булчирхайн хорт хавдар үүсэхэд нөлөөлдөг бэ?

- A. Мах болон өөх тосыг хэтрүүлэн хэрэглэх
- B. Тамхи хэт их татах болон архи тогтмол хэрэглэх
- C. Нойр булчирхайн архаг үрэвсэлт өвчнүүд
- D. Мэргэжлийн хортой нөлөөлөл
- E. Дээрх бүгд

/10./ Уушигны өмөн хаана байрласан үед Горнерийн хам шинж илэрдэг вэ?

- A. Голтын хавдар
- B. Уушигны оройн хавдар
- C. Баруун уушигны дунд дэлбэнгийн хавдар
- D. Улаан хоолойн хавдар
- E. Уушигны хавдарын медиастинал хэлбэр

/11./ Ходоодны субтотал резекцийн үед тайрахгүй үлдээдэг эрхтэн аль нь бэ?

- A. Бага сэмж
- B. Их сэмж
- C. Ходоод-гэдэсний холбоос
- D. Дэлүү
- E. Алийг ч тайрахгүй

/12./ Ходоодны хавдрын ямар хэлбэр нь эрт үедээ энгийн нүдэнд харагддаг вэ?

- A. Шархлаат
- B. Полип
- C. Өнгөц тархмал ба диффуз
- D. Скирр-нэвчдэст хавдар
- E. Дийз хэлбэрт

/13./ Хорт хавдрын алсын үсэрхийлэлд ямар эрхтэн нь оролцдоггүй вэ?

- A. Уушиг
- B. Элэг
- C. Бөөр
- D. Яс
- E. Тархи

/14./ Уушгинд нэг үсэрхийлэлтэй бөөрний өмөнгийн үед нефроэктоми хийх ямар заалт байдаг вэ?

- A. Заалтгүй

- B. Нас хамаарахгүй хийнэ
  - C. Залуу насанд заалттай
  - D. Хижээл насанд заалттай
  - E. Хижээл насанд заалтгүй
- /15./ 1Улаан хоолойн хавдрын мэс заслын дараах илүүтэй тохиолддог хүндрэл юу вэ?
- A. Хагалгааны дараах нас баралт
  - B. Шарх эдгэрэхгүй байх
  - C. Уушигны эмболизм
  - D. Амьсгалын хүндрэлүүд
  - E. Бүгд
- /16./ Ходоодны хавдрын мэс засал эмчилгээний хувьд аль нь үнэн бэ?
- A. Гастрэктомийн хагалгааны үед D1 тайралт, их бага махиа дагасан булчирхайнуудыг түүх нь D2 тайралт хийхээс илүү үр дүнтэй
  - B. Ходоодны хорт хавдрын үед илүүтэй хийгддэг хагалгаа бол өргөтгөсөн D2 тайралт
  - C. Хагалгааны үед түүж авсан булчирхайны тоо амьдрах хугацаанд нөлөөлөхгүй
  - D. Өргөтгөсөн D2 тайралт болон хязгаарлагдмал D1 тайралтын үр дүн ойролцоо
  - E. Ходоодны хорт хавдрын үед илүүтэй хийгддэг хагалгаа бол өргөтгөсөн D1 тайралт
- /17./ Ходоодны хорт хавдрын аль хэлбэр нь удаан явцтай бөгөөд хожуу үсэрхийлэл өгдөг бэ?
- A. Экзофитный
  - B. Нэвчдэст
  - C. Дийз хэлбэрийн
  - D. Шархлаат-нэвчдэст
  - E. Зөв хариулт байхгүй
- /18./ Тимома нь
- A. Ихэнхдээ арын голтод тохиолддог
  - B. Хорт хавдар илүүтэй тохиолддог
  - C. Элгэнд ихэнхдээ үсэрхийлдэг
  - D. Грависын миастени хавсардаг
  - E. Хими туяа эмчилгээнд мэдрэг бус
- /19./ Элэгний анхдагч өмөнгийн үед алсын үсэрхийлэл ихэвчлэн аль эрхтэнд байрладаг бэ?
- A. Яс
  - B. Хэвлийн арын тунгалгийн зангилаанд
  - C. Уушгинд
  - D. Тархинд
  - E. Голтын тунгалгийн зангилаанд
- /20./ Уушигны өмөнгийн үед ямар эрхтэн гэмтсэнээс дууны өнгө өөрчлөгддөг вэ?
- A. Дууны хөвч
  - B. Төвөнхийн хана
  - C. Өрцний мэдрэл
  - D. Эргэх мэдрэл
  - E. Симпатик мэдрэл
- /21./ Ходоодны хорт хавдар үүсэхэд аль нь нөлөөлөх бэ?
- A. Бактерийн халдвар
  - B. Вирусийн халдвар
  - C. Бактерийн болон вирусийн халдвар 2-лаа
  - D. Дээрх 2 халдварын аль нь ч нөлөөлөхгүй
  - E. Дээрх бүх хариулт биш
- /22./ Хөхний өмөнгийн тавиланг ямар хүчин зүйл тодорхойлохгүй вэ?
- A. Өвдөлтийн эрчим
  - B. Эмнэлзүйн хэлбэр
  - C. Гистологи бүтэц ба хавдрын ялгаралын зэрэг
  - D. Диаметр ареол

Е. Хавдрын үе шат

/23./ Хавдрын эсрэг дархлаа, эсийн морф-генетикийн хариу урвал эсийн ялгарал апоптоз, эсийн хуваагдлын өөрчлөлт, мутаци болон бусад генетикийн өөрчлөлтийг үүсгэдэг хүчин зүйлийг юу гэж нэрлэдэг вэ?

- А. Факультативный предрак
- В. Облигатный предрак
- С. Канцероген
- Д. Дисплази
- Е. Хэвийн бус /атипия/

/24./ Хөхний хоргүй хавдрыг эмчлэхэд эдгээрийн аль нь хамгийн үр дүнтэй арга вэ?

- А. Мэс засал
- В. Туяа эмчилгээ
- С. Дааврын
- Д. Эмийн
- Е. Физик эмчилгээ

/25./ Хорт хавдар рентгенд ямар дүрстэй харагдах вэ?

- А. Дугуй сүүдэр
- В. Зууван сүүдэр
- С. Зөв биш хэлбэртэй сүүдэр
- Д. Цацраг маягийн сүүдэр
- Е. Хагас дугуй

/26./ Хавдар ходоодны аль хэсэгт байрласан үед цус багадалт илүү үүсдэг вэ

- А. Амсар хэсэгт
- В. Ёроол болон их биед
- С. Бага махиа
- Д. Гарах хэсэгт
- Е. Их махиа

/27./ Хавдрын эсрэг антибиотик

- А. Адриамицин
- В. Митрамицин
- С. Стрептозоцин
- Д. Ропидин

/28./ Нойр булчирхайн хавдрыноношилгоонд дараах лабораторийн тестээс аль нь илүү ач холбогдолтой бэ?

- А. ЦДШ
- В. Биохимийн шинжилгээ (АСТ, АЛТ, холестерин гэх мэт)
- С. СЕА
- Д. СА 19-9
- Е. Цитрулиновый белок

/29./ Улаан хоолойн кардийн хэсгийн булчирхайлаг эсийн хожуу үеийн хавдрын эмчилгээний оновчтой арга аль нь бэ?

- А. Туяа эмчилгээ
- В. Полихими эмчилгээ
- С. Еюностоми
- Д. Гарлокийн мэс засал
- Е. Гуурс тавих

/30./ Т3N1 ходоодны хавдрын хагалгааны дараах дахилтын аль тодорхойлолт зөв бэ?

- А. Алсын үсэрхийлэл илүүтэй тохиолддог
- В. Ясанд илүүтэй үсэрхийлдэг
- С. Хавдрын лож, гялтан хальс, элэг зэрэг хэвлийн доорх үсэрхийлэл илүүтэй тохиолддог
- Д. Хэвлийн хөндийн лимфийн булчирхайнуудад илүүтэй үсэрхийлдэг
- Е. Уушгинд илүү үсэрхийлдэг

/31./ "Вирхов"-ийн үсэрхийлэл нь дараах эрхтэнд үсэрхийлэх бэ?

- А. Бага аарцгийн эсэд

- В. Өндгөвч
  - С. Хүйсэнд
  - Д. Эгэмний дээд тунгалгийн зангилаанд
  - Е. Дэлүүнд
- /32./ Ясны хавдар ихэвчлэн хаана байрладаг вэ?
- А. Хавирга
  - В. Дунд чөмөг
  - С. Бугалга
  - Д. Шилбэ
  - Е. Сүүж
- /33./ Умайн хүзүүнд крио эмчилгээ хийж болох тохиолдол
- А. Эсийн шинжилгээнд SCC илэрсэн
  - В. Эдийн шинжилгээнд булчирхайлаг эдийн гаж хувирал илэрсэн
  - С. Шинэ болон жинхэнэ уулзвар хэсгүүд 360 градуст тодорхой, эдийн шинжилгээнд эсийн гаж хувирал илэрсэн
  - Д. Хавдрын ургалт 5 см
- /34./ Давсагны хавдар голчлон ямар эрхтэнд үсэрхийлдэг вэ?
- А. Шулуун гэдэс
  - В. Цавины тунгалгийн зангилаа
  - С. Орчны тунгалгийн зангилаа
  - Д. Уушиг
  - Е. Элэг
- /35./ 3-5 см хэмжээтэй салст болон салстын доод давхаргад нэвчсэн хэсэг газрын үсэрхийлэлгүй улаан хоолойн хавдар нь аль үе шат гэж үзэх бэ?
- А. I үе шат
  - В. IIa үе шат
  - С. IIб үе шат
  - Д. IIIa үе шат
  - Е. IIIб үе шат
- /36./ Крукенбергийн метастаз нь аль эрхтэнд байрлах бэ?
- А. Шулуун гэдэс
  - В. Хүйсэнд
  - С. Өндгөвчинд
  - Д. sternocleidomastoid булчинд
  - Е. Тархинд
- /37./ Сүүлийн 10 жилийн дотор ходоодны хорт хавдрын өвчлөл
- А. Өсч байгаа
  - В. Тогтвортой байгаа
  - С. Буурч байгаа
  - Д. Эрэгтэйчүүдийн дунд өсөж, эмэгтэйчүүдийн дунд буурч байгаа
  - Е. Сүүлийн 10 жилийн статистик мэдээлэл байхгүй
- /38./ Хэдэн настайд ходоодны хавдар үүсэх эрсдэл их вэ?
- А. 20 хүртэл
  - В. 21-50 нас
  - С. 51-70 нас
  - Д. 70-с дээш
  - Е. Аль ч насанд хавдар үүсч болно
- /39./ Уушигны хавдрын 3 үе шатны 5 жил амьдрах хувь хэд байдаг бэ?
- А. 10-20%
  - В. 30-40%
  - С. 50-60%
  - Д. 60-70%
  - Е. 80%-иас дээш

- /40./ Ходоодны салстын атираа/ хуниас нь зузаарч, шүүрэл үүсэлт нь ихэсдэг ходоодны хорт хавдрын урьдал өвчнийг нэрлэнэ үү.
- A. Менетрийн өвчин
  - B. Педжетийн өвчин
  - C. Эритроплази Кейра
  - D. Гиршпрунгийн өвчин
  - E. Бареттийн улаан хоолой
- /41./ Түрүү булчирхайн хавдарын T1N0M0 үе шатанд ямар шинж илрэх вэ?
- A. Гематури
  - B. Шээс хаагдах
  - C. Хил хязгаар нь тодорхойгүй, чулуу адил хатуу булчирхай
  - D. Захаар байрлах эмзэглэлгүй ганц нэг зангилаа
  - E. Хярзангийн өвдөлт
- /42./ Хими эмчилгээнд ямар хавдар илүү мэдрэг вэ?
- A. Хондросаркома
  - B. Ясны том эсийн хавдар
  - C. Юингийн хавдар
  - D. Ясны саркома
  - E. Фиброзын гаралтай хавдар
- /43./ Дараах морфологийн хэлбэр нь умайн хүзүүний хавдарт ихэвчлэн тохиолддог. Үүнд:
- A. Хавтгай эст
  - B. Булчирхайлаг эст
  - C. Цайвар эст
  - D. Ялгаралгүй эс
- /44./ Манай улсад хөхний хорт хавдар сүүлийн жилүүдэд:
- A. Буурч байгаа
  - B. Тогтвортой байгаа
  - C. Өсөж байгаа
  - D. Өөрчлөлт бахгүй
- /45./ Билиопанкреатодуоденальхэсгийн хорт хавдрын үед эрт үед ямар өвөрмөц шинж тэмдэг илэрдэг бэ?
- A. Аюулхайд болон ар нуруунд өвдөх
  - B. Жингээ алдах
  - C. Механик шарлалт
  - D. Асцит
  - E. Бөөлжилт
- /46./ TNM ангиллын T ямар шинжийг илэрхийлдэг вэ?
- A. Анхдагч хавдрын хэмжээг
  - B. Хэсэг газрын тунгалагийн булчирхайн байдал
  - C. Алсын үсэрхийллийг
  - D. Хорт хавдрын онцлог шинж
  - E. Хавдрын гистологи бүтэц
- /47./ Түрүү булчирхайн хавдрын хамгийн элбэг тохиолддог хэлбэр юу вэ?
- A. Хорт хавдар
  - B. Аденома
  - C. Фиброма
  - D. Лейкомиома
  - E. Саркома
- /48./ Булчингийн давхарга хүртэл нэвчсэн ганц нэг хэсэг газрын үсэрхийлэлтэй боловч алсын үсэрхийлэлгүй улаанхоолойн хавдар TNM ангиллаар аль үе шат бэ?
- A. T1 N1 M0
  - B. T2 N1 M0
  - C. T3 N0 M0
  - D. T4 N0 M0

Е. Аль нь ч биш

/49./ 4 см хэмжээтэй булчингийн давхаргад нэвчсэн, бага сэмжинд ганц нэг үсэрхийлэлттэй ходоодны хавдрын үе шатыг тодорхойлно уу.

- A. 2А
- B. 2Б
- C. 3А
- D. 3Б
- E. 4

/50./ Анхдагч байрлал аль эрхтэнд байхад элгэнд ихэвчлэн үсэрхийлэл өгдөг бэ?

- A. Хоол боловсруулах замд
- B. Уушгинд
- C. Хөхөнд
- D. Эмэгтэйчүүдийн хавдар
- E. Дээрх бүгд

/51./ Жижиг эсийн уушигны хавдрын үед туяа эмчилгээг ихэвчлэн дараах байдлаар хэрэглэнэ:

- A. Бие даасан эмчилгээ хэлбэрээр
- B. Мэс засал эмчилгээтэй хавсарч
- C. Хими эмчилгээтэй хавсарч
- D. Иммунотерапи болон гормон эмчилгээтэй хавсарч

/52./ Ходоодны салстын эпителийн дисплазийг дараах шинжилгээгээр илрүүлнэ.

- A. Рентген
- B. Ходоодны уян дуран
- C. Эс, эдийн шинжилгээгээр
- D. Дээрх бүгд
- E. Зөв хариулт байхгүй

/53./ Нэвчдэст хавант хавдрын үед ямар эмчилгээ хийх шаардлагатай вэ?

- A. Мэс засал
- B. Зөвхөн туяа эмчилгээ
- C. Хими эмчилгээ
- D. Бүрдэл эмчилгээ
- E. Хавсарсан эмчилгээ

/54./ Манай улсад хөхний хорт хавдрын эрт илрүүлэг үзлэгт хэдэн наснаас хамрагддаг бэ?

- A. 18 нас
- B. 20 нас
- C. 30 нас
- D. 50 нас
- E. 40 нас

/55./ Хавдар ходоодны амсар хэсэгт байрласан үед ямар шинж илрэх вэ?

- A. Хэхрэх, гулгих, бөөлжих
- B. Аюулхай орчимд өвдөх
- C. Дисфаги
- D. Ядрах, сульдах
- E. Гүйлгэх, суулгах

/56./ Шархлаат-нэвчдэст ходоодны хавдрын үед рентген шинжилгээнд ямар шинж илрэх вэ?

1. Эргэн тойрны нугалаасууд арилж гөлийх
2. Нишийн контур ходоодны контурын хүрээнээс илүү гарсан
3. Нишийн ойролцоох хэсэгт гүрвэлзэх хөдөлгөөн байхгүй
4. Нишийн булангууд өргөгдсөн байна.
5. Симптом чаши Клойбера

/57./ Ясны радиоизотопийн шинжилгээгээр ямар өөрчлөлтийг илрүүлж үнэлж болох вэ?

1. Яс тэнхлэгийн дагуу гэмтсэн эсэхийг
2. Хавдрын эдийн бүтцийг

3. Ясанд анхдагч өмөн байгааг
  4. Ясанд үсэрхийлсэн эсэхийг
  5. Эмгэг хугарал гэмтлийг илрүүлэх
- /58./ Элэгний хорт хавдрын төгс эмчилгээний аргуудыг сонгоно уу
1. Өндөр давтамжтай долгионоор түлэх
  2. Мэс засал
  3. Элэг шилжүүлэн суулгах
  4. Судас бөглөх
  5. Этанол
- /59./ Дор дурдсан шинж тэмдгийг багасгах зорилгоор хөнгөвчлөх туяа эмчилгээг хийдэг.
1. Ясны эмгэг хугаралт
  2. Өвдөлт
  3. Хөлрөх
  4. Цус алдалт
  5. Цус багадах
- /60./ Ходоодны хавдраар өвчлөхөд ямар хүчин зүйлүүд нөлөөлдөг вэ?
1. Хоол хүнс болон зөв хооллолт
  2. Хөрс болон цаг уурын нөхцөл
  3. Ходоодны хэсэг газрын салст бүрхэвчийн өөрчлөлт
  4. Удамшлын өвчин
  5. Тамхи татах
- /61./ Амьдралын төгсгөлийн шатанд буй өвчтөнд нөхцөл байдалтай холбоотой амьсгаадах шалтгаан
1. Ядарч сульдах
  2. Цус багадах
  3. Өвдөлт
  4. Сэтгэл түгших
  5. Элэг томрох, хэвлийд шингэн хуримтлагдах
- /62./ Улаан хоолойн өмөнг ямар аргаар эрт илрүүлж оношлож болох вэ?
1. “Өтгөн баритай” рентгенд харах
  2. Амьсгалын эрхтэн ба улаан хоолойн полирентгенографи хийх
  3. Бронхоскопи
  4. Эксфолиатив цитодиагностик
  5. Хроматографийн аргаар дурандаж биопси авах
- /63./ Ямар эмгэгийн үед цөмөлж авах оношлогооны үр дүн илүү байдаг вэ?
1. Ясны эдийн саркома
  2. Арьсны меланома
  3. Лимфома
  4. Арьсны хавдар
  5. Аденокарцинома
- /64./ Дараах хүчин зүйлсийн аль нойр булчирхайн хорт хавдар үүсэхэд нөлөөлдөггүй бэ?
- A. Чихрийн шижин
  - B. Архаг гепатит
  - C. Архаг панкреатит
  - D. Холецистэктоми хийлгэх
  - E. Архаг гастрит
- /65./ Элэгний анхдагч хавдрын үед биохимийн шинжилгээнд аль үзүүлэлт ихсэх бэ?
- A. Шүлтлэг фосфатаза
  - B. Трансаминаза
  - C. Лактатдегидрогеназа
  - D. Гамма-глутаминтранспептидаз
  - E. Дээрх бүх фермент
- /66./ Морфологи бүтцээр нь зөөлөн эдийн хавдрыг юу гэж ангилдаг вэ?



1. Карцинойд
  2. Синовиаль
  3. Полип
  4. Мезотелиол
  5. Нейроген
- /67./ Хөхний өмөн ямар эдээс үүсдэг вэ?
1. Тунгалагийн зангилаа
  2. Цусны судас
  3. Гөлгөр эсвэл хөндлөн судалт булчингаас
  4. Сүүний сувгийн эпителиээс
  5. Дутуу хөгжсөн холбогч эдээс
- /68./ Ясны хорт хавдар голчлон ямар эрхтэн рүү үсэрхийлдэг вэ?
1. Элэг
  2. Уушиг
  3. Зөөлөн эд рүү
  4. Дэлүү
  5. Тунгалгийн зангилаа
- /69./ Хөхний өмөнгийн аль хэлбэрийн үед дааврын эмчилгээг хийх шаардлагатай вэ?
1. Анхдагч хөхний өмөнгийн бүх үе шатанд
  2. Анхдагч тархмал хавдар
  3. Хавдрын дааврын рецептор тодорхой үед
  4. Жирэмслэлт болон хөхний сүүжилттэй холбоотой хавдар
  5. Менопаузтай холбоотой хавдар
- /70./ Дараах хэлбэрүүдийн аль нь уушигны захын хавдарт ордог вэ?
1. Дугуй хэлбэрийн
  2. Хатгалгаа төст
  3. Пенкостын хавдар
  4. Дэлбэнгийн өмөн
  5. Юингийн өмөн
- /71./ Улаан хоолойн салст бүрхэвчийн өөрчлөлтийг ямар аргаар оношлож болох вэ?
1. Шингэн баритай рентген хийх
  2. “Өтгөн баритай” рентгенд харах
  3. Эксфолиатив цитодиагностик
  4. Амьсгалын эрхтэн ба улаан хоолойн полирентгенографи хийх
  5. Дурандаж биопси авах
- /72./ Ясны хавдрыг оношлох гол арга нь:
1. КТГ
  2. Биопси
  3. Рентген зураг
  4. Маркер
  5. эХО
- /73./ Ямар хавдар тамхитай холбоотой үүсдэг вэ?
1. Нойр булчирхайн хавдар
  2. Уушигны хавдар
  3. Амны хөндийн салст бүрхэвчийн хавдар
  4. Давсагны хавдар
  5. Улаан хоолой
- /74./ Уушигны хорт хавдар гистологийн аль хэлбэр нь түгээмэл тохиолддог бэ?
1. Хавтгай эсийн
  2. Жижиг эсийн
  3. Булчирхайлаг
  4. Овьёос төст
  5. Бүгд

/75./ Ходоодны ёроол хэсэгт хавдар байрласан үед хамгийн түрүүнд ямар үйл ажиллагааг алдагдах вэ?

1. Ялгаруулан гаргах хөдөлгөөний үүрэг
2. Хоол тэжээлийн зйл нөөцлөх үүрэг
3. Шүүрлийн
4. Шимэгдүүлэх
5. Цус төлжүүлэх

/76./ 36 настай, баруун хөхний гадна дээд хэсэгт байрласан T1N0M0 үе шат бүхий хавдрыг радикал тайралт хийж авсан. Цаашид ямар эмчилгээ төлөвлөх вэ?

1. Туяа эмчилгээ
2. Ажиглах
3. Өндгөвч авах мэс засал
4. Урьдчилан сэргийлэх хими эмчилгээ
5. Эстроген дааврын эсрэг эмчилгээ

/77./ Эмнэлзүйн ямар шинж дээр үндэслэн улаан хоолойн хавдар сэжиглэх вэ?

1. Хоол горойх
2. Шүлс их гоожих
3. Хоол залгихад хөндүүрлэх
4. Акрокератоз
5. Цус багадах

/78./ Хөхний өмөнгийн ямар хэлбэр тавилан муутай вэ?

1. Зангилаат хэлбэр
2. Нэвчдэст хавантай хэлбэр
3. Байран өмөн /in situ/
4. Олон хэлбэр
5. Педжетийн хавдар

/79./ Морфин хэрэглэж буй өвчтөнд илэрч болох гаж үйлчилгээ

1. Амьсгал дарангуйлагдах
2. Өтгөн хатах
3. Дотор муухайрах бөөлжих
4. Нойрмог болж унтаарах
5. Хөлрөмтгий болох

/80./ Аль арга нарийвчлалыг илүү тодорхойлох вэ?

1. “Өтгөн баритай” рентгенд харах
2. Амьсгалын эрхтэн ба улаан хоолойн полирентгенографи хийх
3. Тодосгогч бодистой КТГ
4. Эксфолиатив цитодиагностик
5. Дурандаж браш биопси авах

/81./ Ямар хавдрыг оношлоход биопси илүү ач холбогдолтой вэ?

1. Яс
2. Хөх
3. Арьсны меланома
4. Зөөлөн эдийн хавдар
5. Ясны анхдагч ретуколсаркома

/82./ 65 настай эмэгтэй, алганы болон чихний омогны арьс гуужиж эхэлсэнээс хойш нэг сарын дараагаас хоол горойж тээглэж эхэлсэн. Ямар урьдчилсан онош тавих вэ?

1. Акроцианоз
2. Улаан хоолойн хавдар
3. Ахалази
4. Дивертикул
5. Шарх сорвижсон

/83./ Хавдрын эсрэг эмийн эмчилгээг юу гэдэг вэ?

1. Хими эмчилгээ
2. Дааврын эмчилгээ

3. Бай эмчилгээ
  4. Туяа эмчилгээ
  5. Хавсарсан эмчилгээ
- /84./ Ходоодны хавдар нугалуур хэсэгт байрласан үед ямар үйл ажиллагаа алдагдах вэ?
1. Ялгаруулан гаргах хөдөлгөөний үүрэг
  2. Хоол тэжээлийн үйл нөөцлөх үүрэг
  3. Шүүрлийн
  4. Бактерицид
  5. Цус төлжүүлэх
- /85./ Хөхний өмөн ямар замаар үсэрхийлдэг вэ?
1. Лимфоген
  2. Гематоген
  3. Гематоген болон лимфоген
  4. Имплантаци
  5. Контакт
- /86./ Хожуу үеийн улаан хоолойн хавдрын төгсгөл буюу кардийн хэсгийн булчирхайлаг эсийн өмөнгийн үед ямар аргаар эмчлэх вэ?
1. Туяа эмчилгээ
  2. Полихими эмчилгээ
  3. Еюностоми
  4. Гарлокийн мэс засал
  5. Гуурс тавих
- /87./ Ходоодны хавдраас урьдчилан сэргийлэх анхдагч ямар арга байх вэ?
1. Утсан болон давсалсан бүтээгдэхүүн бага хэрэглэх
  2. Хоол ундаа яаралгүй идэх
  3. Ногоон өнгийн жимс, ногоог түлхүү хэрэглэх
  4. Хатуу спиртийн төрлийн ундаанаас татгалзах эсвэл минерал болон содтой устай цуг хэрэглэх
  5. Тамхи татахгүй байх
- /88./ Ясны хоргүй хавдрын үед илэрдэг эмнэл зүйн гол шинжүүд
1. Электролит солилцооны алдагдал /Ca, Na, K/
  2. Хавдар байрласан хэсэгт шөнө өвдөх
  3. Хавдар тэмтрэгдэх
  4. Доголох
  5. СОЭ ихсэх
- /89./ Хэт ягаан туяа нь дараах хавдраар өвчлөх эрсдлийг нэмэгдүүлдэг:
1. Уушиг
  2. Арьсны меланома
  3. Хэлний хавдар
  4. Уруулын хавдар
  5. Хөхний хавдар
- /90./ Эрт үеийн элэгний анхдагч өмөнгийн эмчилгээний сонголт юу вэ?
1. Мэс заслын тайралт
  2. Элэг шилжүүлэн суулгах
  3. Спирт шахах
  4. Өндөр давтамжаар шарах
  5. Элэгний артери бөглөх
- /91./ Хөхний өмөнг оношлох ямар арга илүү найдвартай вэ?
1. Цитологи шинжилгээ
  2. Маммографи
  3. Дуктографи
  4. ЭХО
  5. Эдийн шинжилгээ

- /92./ Уушигны өмөн голчлон ямар эд эсийн бүтэцтэй байдаг вэ?
1. Аденокарцинома
  2. Хавтгай эсийн
  3. Жижиг эсийн
  4. Овьёос төст
  5. Булчингийн
- /93./ Улаан хоолойн төгсгөл буюу кардийн булчирхайлаг өмөнг ямар гол аргаар эмчлэх вэ?
1. Туяа эмчилгээ
  2. Полихими эмчилгээ
  3. Хооллох еюностоми
  4. Улаан хоолойн доод 1/3 ба ходоодны хэсгийн субтоталт тайралт
  5. Пластик гуурс тавих
- /94./ Ямар хүчин зүйлүүдүүд эмгэг өөрчлөлтийг үүсгэдэг вэ?
1. 60-аас дээш настайд авсан гэмтэл
  2. 50-аас дээш настай, тамхи татдаг
  3. Ясан дээрх хавдрын деструкци өөрчлөлт
  4. Туяаны нөлөө
  5. Хими эмчилгээ
- /95./ Уушигны өмөн ямар эдээс үүсдэг вэ?
1. Эпители
  2. Мэдрэл
  3. Мөгөөрс
  4. Яс
  5. Булчирхай
- /96./ Захын байрлалтай уушигны хавдар төвийн байрлалтай хавдраас ямар ялгаатай бэ?
1. Эхний үеэсээ эмнэлзүйн илэрхий шинж тэмдэг илэрнэ.
  2. Шинж тэмдэггүй илрэхгүй удаан үргэлжлэнэ
  3. Ханиалгах, цустай цэр гарах зэрэг шинж тэмдэг эрт үед илэрнэ.
  4. Ханиалгах, цустай цэр гарах зэрэг шинж тэмдэг хожуу илэрнэ
  5. Ялгаагүй
- /97./ Ямар хавдар нь илүү хоруу явцтай вэ? /эрт үсэрхийлдэг/
1. Хондросаркома
  2. Ясны анхдагч ретикулосаркома
  3. Паростальная саркома
  4. Ясны саркома
  5. Фиброзын гаралтай хавдар
- /98./ Хөхний хавдрыг ямар өвчнөөс ялган оношлох шаардлагатай вэ?
1. Зангилаат мастит
  2. Гемобластоз
  3. Мастит
  4. Туберкулёз
  5. Анеми
- /99./ Улаан хоолойн үйл ажиллагааг ямар аргаар үнэлж болох вэ?
1. “Өтгөн баритай” рентгенд харах
  2. Эксфолиатив цитодиагностик
  3. Амьсгалын эрхтэн ба улаан хоолойн полирентгенографи хийх
  4. Шингэн баритай рентген хийх
  5. Дурандаж биопси авах
- /100./ Зөөлөн эдийн хавдар голчлон хаана байрладаг вэ?
1. Булчингийн давхаргад
  2. Дээд доод мөчдөд
  3. Цавинд
  4. Цээжний хэсэгт
  5. Хэвлийн хөндийн эрхтэнүүдэд

- /101./ Ходоодны хорт хавдрын төгс мэс заслыг нэрлэнэ үү.
1. Гастрэктоми
  2. Дисталь субтоталь тайралт
  3. Проксималь субтотал тайралт
  4. Ходоодны 1/2-ийг тайрах
  5. Ходоодны хавдартай хэсгийг шаант хэлбэрээр авах
- /102./ Хөхний хавдрыг эрт илрүүлж оношлоход ямар арга нь илүү вэ?
1. КТГ
  2. Хөхөө өөрөө шалгах
  3. Хөхний эхо
  4. Маммографи
  5. Мэс заслын эмчид үзүүлэх
- /103./ Ходоодны хавдар аль хэсэгт байрласан үед огих болон бөөлжилт үүсдэг вэ?
1. Амсар хэсэгт
  2. Ёроол болон их биед
  3. Бага махиа
  4. Гарах хэсэгт
  5. Их махиа
- /104./ Өндгөвчний үйл ажиллагааг ямар аргаар дарангуйлах вэ?
1. Лапароскопийн тусламжтай өндгөвч авах
  2. Туяа эмчилгээний тусламжтай
  3. Гозерелин
  4. Тамоксифен
  5. Вакцин
- /105./ Мэс заслын дараа залгасан улаан хоолойн хавдрын дахилт яагаад эрт үүсдэг вэ?
1. Салстын доод давхраа үгүй учраас
  2. Салст бүрхэвч нимгэн учраас
  3. Серозон давхарга байхгүй тул
  4. Судасжилт багатай
  5. Мэдрэлжүүлэлт багатай
- /106./ Ямар шалтгаанаас болж хавдар үүсэх вэ? /яс/
1. Өсөлтийн бүс дэх бодисын солилцооны алдагдал /эпифизийн мөгөөрсөн хэсэгт/
  2. Хуучин гэмтлээс
  3. Ясны бэртэл өөрчлөлт
  4. Паратироид гаралтай остеодистрофи
  5. Төрөлхийн ясны гэмтлээс
- /107./ Элэгний хорт хавдрын эрт илрүүлэг үзлэгт аль шинжилгээний аргыг хэрэглэх бэ?
1. Биохимийн шинжилгээ
  2. АФП
  3. КТГ
  4. ЭХО
  5. Элэгний вирусийн шинжилгээ
- /108./ Хөхний өмөн ямар эрхтэнд голчлон үсэрхийлдэг вэ?
1. Яс
  2. ЯУушиг
  3. Тархи
  4. Элэг
  5. Бөөр
- /109./ Улаан хоолойн өмөнгийн эпидермиологийн хувьд аль хариулт нь зөв бэ?
1. Эмэгтэйчүүд илүү өвчлөмтгий байдаг
  2. 50-ээс дээш насныханд илүү тохиолддог
  3. Нийт хавдрын өвчлөлд тархалтаараа 1 рт ордог
  4. Баруун аймгийн иргэдэд илүү тохиолддог
  5. Өмнөговь аймгийн хүмүүст

- /110./ Хавдар ходоодны антраль буюу гарах хэсэгт байрласан үед ямар шинж илрэх вэ?
1. Өмхийгөөр хэхрэх
  2. Хоол идсэний дараа бөөлжих
  3. Аюулхайд хүнд оргих
  4. Бөөлжсөний дараа хөнгөрөх
  5. Гүйлгэх
- /111./ Өвчтөний эмчилгээний үр дүн юунаас хамаарах вэ?
1. Ясны изотоп шинжилгээний хариу
  2. Хавдрын морфологи бүтэц
  3. Биохимийн үзүүлэлт /ШФ, ЛДГ/
  4. Хавдрын байрлал ба хэмжээ
  5. Бөөр, нойр булчирхайн эхоны хариу
- /112./ Төвийн байрлалтай уушигны хавдрын морфологи бүтцийг шинжлэх гол арга нь юу вэ?
1. Цэрний шинжилгээ
  2. Фибробронхоскопи
  3. Трансторакаль
  4. Унтуулгатай бронхоскопи
  5. Медиастиноскопи
- /113./ Уушигны төвийн байрлалтай хавдрын үеийн эрт үед илрэх шинж тэмдгийг нэрлэнэ үү.
1. Ханиах
  2. Цээжээр өвөх
  3. Цустай цэр гарах
  4. Хоолой сөөх
  5. Халуурах
- /114./ Хөхний хавдрын ямар тохиолдолд төгс мэс засал хийх вэ?
1. I үе
  2. IIa үе
  3. II б үе
  4. III үе
  5. IV үе
- /115./ Юунаас болж трахеозофагийн свищ үүсдэг вэ?
1. Улаан хоолойн доод хэсгийн өмөн
  2. Улаан хоолойн дунд хэсгийн өмөн
  3. Улаан хоолойн дээд хэсгийн өмөн
  4. Улаан хоолойн өмөн цагаан мөгөөрсөн хоолой руу цөмөрсөнөөс
  5. Улаан хоолойн доод дунд хэсгийн өмөн
- /116./ Зөөлөн эдийн хавдрын талаар ямар шинжилгээ нь илүү мэдээлэл өгдөг вэ?
1. Радиоизотопын арга
  2. Соронзон резонанс томографи
  3. КТГ
  4. Биопси
  5. Маркер
- /117./ Хөхний нэвчдэст хавант хавдрын үед ямар эмчилгээ хийх шаардлагатай вэ?
1. Мэс засал
  2. Зөвхөн туяа эмчилгээ
  3. Хими эмчилгээ
  4. Хавсарсан эмчилгээ
  5. Бүрдэл эмчилгээ
- /118./ Умайн хүзүүний өмөнг эрт илүүлж оношлоход ямар арга нь илүү вэ?
1. Кольпоцитодиагностик
  2. Эмэгтэйчүүдийн эмчид үзүүлэх
  3. Үтрээний эхо
  4. PAP сорил

5. Хусаж шинжлэх

/119./ Элэгний анхдагч хавдрын үед

- A. Өвчний тодорхой шинж тэмдэггүй мөн элэгний үйл ажиллагааны алдагдал байхгүй
- B. Тодорхой шинж тэмдэггүй боловч элэгний үйл ажиллагааны алдагдал илэрнэ
- C. Өвчний тодорхой шинж тэмдэг илрэх боловч элэгний үйл ажиллагааны алдагдлын шинж байхгүй

D. Элэгний үйл ажиллагааны алдагдлын улмаас өвчний эхний үе шатанд эмнэлзүйн тодорхой шинж тэмдэг илэрнэ

/120./ Уушигны хорт хавдрын үед ихэвчлэн дараах тунгалгийн зангилаанд үсэрхийлдэг:

- A. Цээжний хөндийн
- B. Суганы доод
- C. Гялтангийн арын
- D. Цавины
- E. Хэвлийн

/121./ Хүний генетикийн онцлог нь ходоодны хавдрын дараах хэлбэр үүсэхэд нөлөөлнө:

- A. Ходоодны хавдрын диффузний хэлбэр
- B. Ходоодны хавдрын интестинальн хэлбэр
- C. Ходоодны хавдрын бүх хэлбэр
- D. Ямар ч нөлөө үзүүлэхгүй
- E. В болон Г хариулт зөв

/122./ Дааврын шалтгаант паранеопластиз синдром яагаад үүсдэг вэ?

- A. Хавдрын эсээс ялгарах дааврын улмаас
- B. Бамбай булчирхайн хавдрын үед
- C. Метастаз бөөрний дээд булчирхайн өгсөн үед
- D. Ходоодны хавдар нойр булчирайд үсэрхийлсэн үед
- E. Өнчин тархины үйл ажиллагаа дарангуйлагдсан үед

/123./ Хөхний хавдрыг оношлоход ямар агра хэрэглэгдэхгүй вэ?

- A. Харах
- B. Тэмтрэх
- C. Тогших
- D. ЭХО
- E. Маммографи

/124./ Давсагны хавдрын үед илэрдэг үндсэн шинж юу вэ?

- A. Шээс нарийн гарах
- B. Дизурия
- C. Өвдөлт
- D. Гематурия
- E. Шээс саатах

/125./ Хөхний хавдрын аль шатанд төгс мэс засал хийх вэ?

- A. I үе
- B. IIa үе
- C. II б үе
- D. III үе
- E. IV үе

/126./ Монгол улсад ходоодны хорт хавдар хавдрын өвчлөлийн дотор хэддүгээр байранд ордог бэ?

- A. Нэгдүгээр
- B. Хоёрдугаар
- C. Гуравдугаар
- D. Эхний гуравт ордоггүй
- E. Дээрхээс аль нь биш

/127./ Ходоодны хавдар аль хэсэгт байрласан үед дисфаги үүсдэг вэ?

- A. Амсар хэсэгт
- B. Ёроол болон их биед

- C. Бага махиа
- D. Гарах хэсэгт
- E. Их махиа

/128./ Хорт хавдрын эс эдэд химийн ямар элемент багасдаг вэ?

- A. Кальци
- B. Магни
- C. Фосфор
- D. Ус
- E. Гликолиз

/129./ Зөөлөн эдийн хорт хавдрын сэжигтэй тохиолдолд эдийн шинжилгээг ямар аргаар авах вэ?

- A. Хавдрын энуклеаци
- B. Эксцизийн биопси
- C. Инцизийн экспресс биопси
- D. Төлөвлөгөөт инцизийн биопси
- E. Хатгалтын биопси

/130./ Юингын хавдар дунд чөмөгний хаана байрладаг вэ?

- A. Метафиз
- B. Эпифиз
- C. Метаэпифиз
- D. Диафиз
- E. Сэртэнд

/131./ Өндгөвчийн поликистозын үед:

- A. Фолликул сэдээгч дааврын түвшин ихэснэ
- B. Лактогены дааврын түвшин ихэснэ
- C. Фолликул сэдээгч, Лактогены дааврын түвшин ихэснэ
- D. Фолликул сэдээгч дааврын түвшин буурна

/132./ Нойр булчирхайн хорт хавдар аль хэсэгт ихэвчлэн тохиолддог бэ?

- A. Толгой
- B. Их бие
- C. Сүүл
- D. Дээрх байрлалд ижил давтамжтай
- E. Сэрээ хэлбэрийн сэртэн

/133./ TNM ангиллын N ямар шинжийг илэрхийлдэг вэ?

- A. Анхдагч хавдрын хэмжээг
- B. Хэсэг газрын тунгалагийн булчирхайн байдал
- C. Алсын үсэрхийллийг
- D. Хорт хавдрын онцлог шинж
- E. Хавдрын гистологи бүтэц

/134./ Хоргүй хавдрыг эмчлэхэд эдгээрийн аль нь гол арга вэ?

- A. Мэс засал
- B. Туяа эмчилгээ
- C. Дааврын
- D. Эмийн
- E. Физик эмчилгээ

/135./ Бүдүүн-шулуун гэдэсний хавдруудаас аль байрлалын хавдар нь туяа эмчилгээнд илүү мэдрэг вэ?

- A. Мухар гэдэс
- B. Өгсөх гэдэс
- C. Уруудах гэдэс
- D. Аналь хэсэг

/136./ Ходоодны салст бүрхэвчийн ямар өөрчлөлтийг хавдрын урьдал гэж үзэх вэ?

- A. Атипийн эс
- B. Дисплазийн өөрсчлөлтөнд орсон эс



- C. Архаг хатингаршилт үрэвсэл
- D. Гэдэсний дисплази
- E. Атрофи

/137./ 45 настай эрэгтэй баруун мөр өвдөж, мэдрэхүй буурсан гэсэн зовиуртай. Рентген, КТГ-ын шинжилгээнд баруун уушгины оройд 5 см цээжний хана руу нэвчсэн үүсгэвэртэй. Угийн болон голтын булчирхай томроогүй, алсын үсэрхийлэлгүй. Уушиг дурандаж эсийн шинжилгээ авахад дунд ялгаралтай булчирхайлаг өмөн илэрсэн. Ямар эмчилгээ хийх вэ?

А. Неоадювант платинум хими эмчилгээг хэсэг газрын туяа эмчилгээтэй хавсарч дараа нь мэс засал хийнэ

- B. Хавсарсан хими туяа эмчилгээ
- C. Хэрэв PET шинжилгээнд голтын үсэрхийлэл үгүй бол шууд мэс засал
- D. Өндөр тунгаар туяа эмчилгээ

/138./ Адьювант хими эмчилгээг ихэвчлэн аль хавдрын үед хэрэглэдэг бэ?

- A. Уушигны хавтгай эсийн хавдар
- B. Уушигны аденокарцинома
- C. Уушигны жижиг эсийн хавдар
- D. Дээрх бүх тохиолдолд
- E. Батлагдаагүй

/139./ Улаан хоолойн хавдрын үед илрэх эмнэлзүйн шинж тэмдэг юу вэ?

- A. Цус багадалт
- B. Хэвлийн өвдөлт
- C. Горойх ба турах
- D. Цустай ханиа
- E. Цустай баах

/140./ Аль нь ходоодны хорт хавдрын урьдал өвчин биш бэ

- A. Архаг атрофический гастрит
- B. Ходоодны шархлаат өвчин
- C. Гиперпластик полип
- D. Аденоматозный полип
- E. Пернициозная анемия

/141./ TNM ангиллын M ямар шинжийг илэрхийлдэг вэ?

- A. Анхдагч хавдрын хэмжээг
- B. Хэсэг газрын тунгалагийн булчирхайн байдал
- C. Алсын үсэрхийллийг
- D. Хорт хавдрын онцлог шинж
- E. Хавдрын гистологи бүтэц

/142./ 35 настай 8н долоо хоногтой жирэмсэн эмэгтэйн баруун хөх хатууран томорч, хөхний толгойноос цусархаг ялгадас гарч улмаар баруун суганы тунгалагийн булчирхай томорсон. Ямар арга хэмжээ авах вэ?

- A. Физик эмчилгээ
- B. Баруун хөх болон суганы тунгалагийн булчирхайнаас эсийн шинжилгээ авах
- C. Антибиотик эмчилгээ хийх
- D. Цусны дэлгэрэнгүй шинжилгээ
- E. Маммографи

/143./ Төмсөгний өмөн үүсгэдэг гол хүчин зүйл юу вэ?

- A. Бэлгийн сулрал
- B. Төмсөгний гэмтэл
- C. Халдвар
- D. Крипторхизм
- E. B,C,D хариулт зөв

/144./ Ходоодны амсар хэсэгт байрлалтай нарийсалт үүссэн хожуу үеийн хавдартай өвчтөнд ямар эмчилгээ хийх бэ?

- A. Туяа
- B. Гастростоми

C. Гастроэнтеростоми

D. Хими

E. Шинж тэмдгийн

/145./ Аль нь улаан хоолойн эпителийн гаралтай хоргүй хавдарт орохгүй бэ?

A. Полип

B. Аденом

C. Папиллом

D. Лейомиом

E. Бүгд

/146./ Өвчтөнд бүхэл хоол идэхэд горойх, халуурах, турах, залгих үед байнга ханиалгах зовиур илэрсэн. Шохойтой улаан хоолой ходоодны рентген зураг авахад улаан хоолойн дунд хэсэгт үүсгэвэртэй, цагаан мөгөөрсөн хоолой улаан хоолойн фистул илэрсэн. Дурангийн шинжилгээнд хавтгай эсийн хавдар тогтоогдсон ба хавдар цагаан мөгөөрсөн хоолойд нэвчсэн байсан. КТГ-ын шинжилгээнд 2 талын уушиг элгэнд олон тооны үсэрхийлэлтэй. Анхны эмчилгээ юу вэ?

A. 5-Fu, цисплатин ба туяа эмчилгээ

B. Хавсарсан хими эмчилгээ

C. Улаан хоолой тайрах

D. Улаан хоолойд стэнд тавих

E. Туяа эмчилгээ

/147./ 4 см хэмжээтэй, булчингийн давхаргад нэвчсэн, хэсэг газрын үсэрхийлэлгүй ходоодны хавдрын TNM ангилалын дагуу оношийг тавина уу.

A. T1N1M0

B. T1N0M0

C. T2N1M0

D. T2N0M0

E. T3N0M0

/148./ Ясны өмөнгөөр нэдэн насны хүн илүү өвчилдөг вэ?

A. 1-5 нас

B. 10-20 нас

C. 21-30 нас

D. 40-50 нас

E. 30 хүртэл нас

/149./ Нойр булчирхайн хорт хавдрын төгс эмчилгээг нэрлэнэ үү:

A. Мэс засал

B. Туяа эмчилгээ

C. Хими эмчилгээ

D. Гормон эмчилгээ

E. Иммунотерапия

/150./ Умайн хүзүүний эмнэлзүйн илрэлгүй өмөнгийн үед гистологит материалыг ямар аргаар авч явуулах вэ?

A. Скальпелаар

B. Конхотомоор

C. Цахилгаан хутгаар

D. Хусуураар

E. Фолькманы хутгаар

/151./ Асбест уушигны хорт хавдар үүсэх талаар дараах тодорхойлолтын аль нь худал вэ?

A. Асбестаг нэрвэгдсэний дараа 5 жилийн дотор уушигны хавдар үүсдэг

B. Тамхидалт нь асбест болон бусад үүсгэгчдийн хавдар үүсэх магадлалыг нэмэгдүүлдэг

C. Хавдар үүсэх магадлалын судалгааны үр дүн янз бүр байсан

/152./ Нойр булчирхайн толгой хэсгийн хавдрын үед ямар шинж тэмдэг илрэх бэ?

A. Шарлалт

B. Аюулхайд өвдөх

- C. Халуурах
- D. Захын судасны тромбоз
- E. Тураал

/153./ Ходоодны хавдар нугалуур буюу (пилорический) хэсэгт байрласан үед ямар шинж тэмдэг илрэх бэ?

- A. Гүйлгэх, суулгах
- B. Дисфаги
- C. Өлөн үед "Ус дусах чимээ"
- D. Дотор муухайрах
- E. Дээрх бүгд зөв

/154./ Хавдрын эс үүсэхэд юу нөлөөлдөг вэ?

- A. Апоптоз алдагдах
- B. Эсийн хэт үржил
- C. Эсийн генетикийн бүтцийн өөрлөлт
- D. Бодисын солилцооны өөрчлөлт
- E. Эсийн бичил өөрчлөлт

/155./ Ямар өөрчлөлтүүд нь ходоодны хорт хавдарт шилжих магадлал өндөр вэ?

- A. Гиперпласт
- B. Аденоматоз
- C. Аденопапилломатоз
- D. Папиллярны аденом
- E. Гистологи бүтцээсээ хамаарахгүй бүгд хорт хавдарт шилждэг

/156./ Бөөрний хавдар ямар хүйсэнд элбэг тохиолддог вэ.

- A. Эмэгтэйчүүдэд 2 дахин
- B. Эрэгтэйчүүдэд 2 дахин
- C. Эмэгтэйчүүдэд 4 дахин
- D. Эрэгтэйчүүдэд 5 дахин
- E. Өвчлөл адил

/157./ Хоргүй хавдрын онцлог шинж

- A. Алсад үсэрхийлдэг
- B. Түрж ургасан шинж чанартай
- C. Эрүүл эдээс хавдрын эд ялгарч харагддаг
- D. Удаан ургалттай
- E. 100% хорт хавдарт шилжих магадлалтай

/158./ Ходоодны хавдрын хожуу (T3N2M1) шатанд хөнгөвчлөх мэс заслыг дараах тохиолдолд хийнэ:

- A. Ходоодны гарах хэсгийн декомпенсаци бүхий нарийсал
- B. Ходоодноос цус алдах
- C. Биеийн байдал харьцангуй тогтвортой дунд зэргийн үед
- D. Хагалгаа хийхэд техникийн хувьд хүндрэл, саадгүй бол
- E. Дээрх бүгд

/159./ Тунгалгийн зангилаанд үсэрхийлсэн, 1см хэмжээтэй бамбай булчирхайн хорт хавдрыг TNM-ээр ангилна уу?

- A. T0N1M1
- B. T1aN1M0
- C. T1bN1M1
- D. T2aN1M0
- E. T2bN2M1

/160./ Эрэгтэйчүүд ямар хавдраар илүү өвчлөмтгий байдаг вэ?

- A. Улаан хоолой
- B. Ходоод
- C. Нойр булчирхай
- D. Бүдүүн гэдэс
- E. Уушиг

- /161./ Умайн хүзүүний дисплазиг оношлоход хамгийн үр дүнтэй шинжилгээний арга
- A. Эсийн шинжилгээ
  - B. Эдийн шинжилгээ
  - C. Толиор шинжлэх
  - D. Кольпоскопи
- /162./ Нойр булчирхайн толгой хэсгийн хавдрын үеийн шарлалт нь:
- A. Тогтвортой, маш удаан явцтай, нэмэгдэхгүй
  - B. Тогтвортой, маш хурдан нэмэгдэнэ
  - C. Нэмэгдэх, багасах гэсэн үечлэлтэй
  - D. Дээрх бүгд байж болно
  - E. Зөв хариулт байхгүй
- /163./ Улаан хоолойн хавдрын TNM ангиллыг тодорхойлоход аль шинжилгээ нь чухал вэ?
- A. Дурангийн хэт авиа шинжилгээ
  - B. Шохойтой улаан хоолойн рентген шинжилгээ
  - C. Цээж хэвлий КТГ
  - D. МРТ
  - E. PET
- /164./ Хорт хавдартай тэмцэх хөтөлбөрийн гол зорилго юу вэ?
- A. Хорт хавдрыг эрт илрүүлэх оношлогооны чанарыг сайжруулах
  - B. Хорт хавдраар өвчлөхийг бууруулах
  - C. Хорт хавдрын нас баралтыг бууруулах
  - D. Өвчтөний амьдралын чанарыг сайжруулах
  - E. Хорт хавдрыг эсрэг эмчилгээний үргүй зардлыг бууруулах
- /165./ 65 настай өвчтөн эстроген дааварт эерэг, T3N1M0 үе шат бүхий хөхний өмөнтэй өвчтөнд аль нь тохиромжтой вэ?
- A. Антиэстроген
  - B. Глюкокортикоид
  - C. Прогестин
  - D. Эстроген
  - E. Андроген
- /166./ Төмсөгний хавдрын үед илэрдэг ямар онцлог шинж байдаг вэ?
- A. Хавдрын үүсгэвэр мэдэгдэхүйц тэмтрэгдэнэ
  - B. Үрийн сувганцарын венийн өргөсөл
  - C. Цавины тунгалгийн зангилаа томрох
  - D. Гялтангийн арын тунгалагийн зангилаа томрох
  - E. Гемоспермия
- /167./ Улаанхоолойн хорт хавдрын нэгдүгээр шатанд хавдар дараах давхаргад нэвчсэн байна.
- A. Салст бүрхэвчинд
  - B. Салст болон салстын доод давхаргад
  - C. Салст болон салстын доод давхарга, булчингийн давхаргад
  - D. Адвентицээс бусад улаанхоолойн бүх давхарга
  - E. Аль нь ч биш
